



**МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/465

Мандалговь

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 тоот захирамжийн 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын газар, хэлтэс, агентлагууд, сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн ахлагч: Ц.Эрдэнэсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
- Нарийн бичгийн дарга: Г.Самданцоодол (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)
- Гишүүдэд:
  - Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
  - Б.Түвшинбаяр (Хууль эрх зүйн хэлтсийн дарга)
  - Н.Сүхбаатар (Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
  - М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
  - Г.Бадамсүрэн (Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
  - Э.Одончимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
  - Н.Дэлгэрмаа (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)
  - Д.Даариймаа (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх удирдамж, аргачлалыг боловсруулан батлуулж, ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Эрдэнэсүрэн), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга (Г.Самданцоодол) нарт тус тус даалгасугай.

Гурав. Газар, хэлтэс, агентлагууд болон сумдын Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 13 - ны өдрөөс 1 дүгээр сарын 24 -ний өдөр хүртэл хугацаанд удирдамж, аргачлалын дагуу чанартай явуулж, дүнг Засаг даргын Зөвлөлийн хуралд 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ